



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/11

Сүхбаатар сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", 29.2, "Агаарын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.4, 8.1.5, 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, Байгаль орчин, аягал жуулчлалын сайдын 2018 оны "Журам батлах тухай" А-479 тоот тушаалын 3.2, 3.3, 3.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэл явуулах, агаарын чанарыг тодорхойлох, агаарт ялгарч буй бохирдуулагч бодисын ялгаргыг тооцож гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

З.Түвшинтөгс

-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Нарийн бичгийн дарга:

М.Рэгзэдмаа

-Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга

Гишүүд:

Ж.Отгонхүү

-Мэргэжлийн хяналтын газрын дарга

Ж.Батцогт

-Авто тээврийн төвийн дарга

Э.Эрдэнэбаатар

-Сэлэнгэ энерго ОНӨААТҮГ-ын дарга

-Бүх сумдын Засаг дарга, багийн Засаг дарга нар

2. Аймгийн хэмжээнд агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогыг 2020 оны 03 дугаар сарын 01-ний дотор, агаарын чанар тодорхойлох, агаарын бохирдлыг бууруулах төлөвлөгөө боловсруулах ажлыг 2020 оны 12 дугаар сарын 15-ны дотор заавар журмын дагуу шуурхай зохион байгуулж, үр дүнг нэгтгэн аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга /М.Рэгзэдмаа/-д үүрэг болгосугай.

3. Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тоо бүртгэл явуулах, агаарын чанар доройтсон газарт агаарын чанарыг тодорхойлох нарийвчилсан хэмжилт хийх ажлын зардлын 4000000 /дөрвөн сая/ төгрөгийн зардлыг хавсралтаар баталж, санхүүжилтийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /З.Түвшинтөгс/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ